

Өндөр гэгээн Занабазарын эх Ханджамц хатны удам гарлыг нягтлах нь

Ц.Цэрэндорж
(Монгол Улсын Их Сургууль)

Abstract: The opinion that Khandjamts hatan is a daughter of Dalai taish of Durbed tribe is widely accepted among the Mongolian scholars. However, this opinion is based only on the manuscript which called “The Biography of Undur gegeen”. There is no enough evidence because there are different records on the origin of Khandjamts hatan in historical sources such as *the daughter of a daughter of a younger brother of Ochir Khan (Abatai Sain Khan)* or *the Queen of the King of Qarsiri*. In this paper, we have tried to make clear the origin of Khandjamts khatan comparing the relating information in various historical sources, not only religious sources such as “The Biography of Undur gegeen” but also official chronicles written in Mongolian and Manchu languages.

Keywords: *Khandjamts hatan, Undur gegeen Zanabazar, Dalai taish, marriage between the Khalkh Royal Clan and the Oirad Royal Clans*

Халхын Жибзундамба хутагтын анхдугаар дүр Өндөр гэгээн Занабазарын намтрын судлал сүүлийн үед улам эрчимтэй хөгжиж байна. Үүнд гагц түүний намтар төдийгүй эцэг, эх, ах дүүгийн нь намтрын судалгаа бас хамаарагдах агаад түүний нэгэн жишээ нь Өндөр гэгээний эх Ханджамц хатны талаарх судалгаа юм. Гэвч монгол хатдын намтар судлал нь баримт хэрэглэгдэхүүн дутагдалтай байдгийн улмаас төдий л өндөр төвшинд хүрч чадаагүй байна. Ялангуяа XX зуунаас өмнөх үед амьдарч байсан хатдын судалгаанд ийм тал ажиглагддаг. Түүний нэгэн адил Ханджамц хатны намтрын судалгаа ч хангалттай хэмжээнд хийгдсэн гэж хэлэх боломжгүй юм. Тухайлбал, Ханджамцыг Дөрвөдийн Далай тайшийн охин гэж үздэг нь маргаантай асуудлын нэг бөгөөд энэхүү үзлийн гол үндэслэл бол “Өндөр гэгээний намтар”-ын нэг хувилбар дахь “Өөлдийн Далай хааны авхай Ханджамц” хэмээх мэдээ болой. Тус намтар дахь “Далай хаан” хэмээгчийг судлаачид Дөрвөдийн Далай тайш хэмээн үзсэн байдаг.¹ Гэтэл бусад сурвалжид Ханджамц хатны гарлыг харилцан адилгүй тэмдэглэсэн нь бидний анхаарлыг татсаны дээр Далай тайшийн охин болох тухай Ойрадын түүхийн сурвалжид ч, Халхын томоохон түүхэн сурвалжид ч огт гардаггүй нь Ханджамц хатны удам гарлын асуудлыг дахин нягтлах шаардлагатайг харуулж байна. Тиймээс энэхүү өгүүлэлд сурвалж бичгийн мэдээнд тулгуурлан Ханджамц хатны удам гарлыг дахин нягтлахыг оролдъё.

¹ Д.Дашбадрах, Монгол-Түвэдийн улс төр, шашны харилцааны түүх (XVI-XVIII зуун), бот I, УБ., 2012, 53-р тал.

А.Очир, Занабазарын угсаа гарлын тухай - Өндөр гэгээн Занабазар: амьдрал, өв, УБ., 2015.

Д.Энхцэцэг, Ханджамц хатаны тухай – Oirad Studies 2, Budapest, 2016.

Дээр өгүүлсэнчлэн Ханджамц хатны гарлыг “Далай ханы охин” гэсэн тэмдэглэлийг XVI зууны сүүлч XVII зууны эхэн хагаст амьдарч байсан Дөрвөд аймгийн Далай тайштай холбон үзэх нь үндэслэл муутай юм. Учир нь Халх Монгол, Ойрад болон Манжийн төрийн албан сурвалжуудад энэ талаар огт тэмдэглэгдэн үлдээгүй байдаг.

Шашны түүхийн сурвалжуудад ч гэсэн хатны гарлыг хэд хэдэн янзаар тэмдэглэжээ. Тухайлбал: Зая бандид Лувсанпэрэнлэйн бичсэн Өндөр гэгээний “Ердийн товч намтар”-т:

“... Түүний (Эрхий мэргэн ханы- Ц.Ц.) агь нь Очир Түшээт хаан хэмээх шашин төр хоёрыг агуу ихэд болгоон үйлдэгч болой. Тэр нь энэхүү Богдын эцэг мөн бөгөөд эх нь ч энэхүү Богдын өөрийн өвөг эцэг Очир их хааны дүүгийн охины охин гоо үзэсгэлэнт, сайхан авирт, хатдын эрдэм төгөлдөр Ханджамц хэмээгч болой. Богд нь энэхүү эцэг эх хоёрын хүү болон Нацоддан хэмээх модон гахай жилийн Хор Монголын есдүгээр сарын хорин тавны өглөө олон гайхамшигт өлзий бэлгэ үзүүлэн мэндлэв”² хэмээсэн бол, бусад “Өндөр гэгээний намтар”-т:

“Эх нь ч Богдын түүний өвөг Очир их хааны дүүгийн охины охин мөн бөгөөд ийн хэмээн, “Хатан үзвээс гуа, сайхан зан аальт” хэмээдэг мэт тэрээр өнгө үзэсгэлэнт бөгөөд сэтгэлд зохистой, гуа сайхан агаад хатан эрдэнэ лүгээ адил зан ааль шулуун шударга, гурван эрдэнэд сүсэг төгөлдөр Ханджамц хэмээх нэгэн ажээ.”³

... Гуравдугаар үе ач хөвгүүн Гомбодоржид хойт этгээдээс Өөлдийн Далай хааны авхай Ханджамцыг өргөөлснөөс, гайхамшигийн олон шинж төгөлдөр сайн хөвгүүн гарсан тэр нь Өндөр гэгээн болой.⁴

... Түшээт хан Гомбодоржид Харшир (qarsiri)-ын хааны хатан Ханджамц хэмээхийг хатан болгосон...⁵

гэх мэтээр зөрүүтэй тэмдэглэсэн байна. Нэг буюу ижил төстэй сурвалжийн хувилбаруудад ийнхүү зөрүүтэй байгаа нь Ханджамц хатны удам гарлыг дахин нягтлах зайлшгүй шаардлагатайг харуулж байна.

Ялангуяа Зая бандид Лувсанпэрэнлэй нь Өндөр гэгээнтэй нэгэн цаг үед амьдарч байсан шадар дотно хүн тул түүний бичсэн намтрын мэдээ нь нэлээд итгэмжтэй гэж үзэж болно. Гэтэл тэнд Ханджамцыг ойрад гаралтай тухай огт дурдаагүй нь хачирхалтай.

Ханджамцыг “Харширын хааны хатан” гэдгийн хувьд, Харшир гэдэг нь Харашар нутгийг заасан үг байх боломжтой гэж үзэж байна. Тухайн үед дөрвөдүүд өнөөгийн Увс аймгийн нутагт бус, бүр баруун тийш нутаглаж байсан агаад өнөөгийн Хятадын Харашарын нутагт өнөө болтол торгууд, хошуудууд

² Өндөр гэгээний намтрууд оршивой, эрхлэн хэвлүүлсэн Ш.Бира, Ш.Сонинбаяр, Д.Дашбадрах, УБ., 1995.

³ Агваанлуvsандондов цорж, Өндөр гэгээний намтар, орчуулсан Ж.Ерөөлт, УБ., 2014, 23-р тал.

⁴ Эрдэнэзуугийн түүх, Өндөр гэгээний намтар: Эрдэнэ зуугийн түүх, Жэбзүндамбын гурван дүрийн түүх, хоёр зүйлийн зохиол дэвтэр дотор буй, УБ., 2015, 42-43-р тал.

⁵ Эрдэнэзуугийн түүх, Өндөр гэгээний намтар: Өндөр гэгээний намтар хэмээх судар оршив, УБ., 2015, 215-р тал.

оршин суудаг билээ. Энэ мэдээнээс үзвэл, Ханджамц нь Ойрадын ноёны охин бус, харин хатан байсныг Түшээт хан Гомбодорж булааж авсан гэж ойлгогдохоор байгаа нь хачирхалтай.

Үүнээс гадна, шашны түүхийн зарим зохиолд өгүүлснээр Ханджамцын хоёр нагац (эгч дүү нар) Түшээт ханы угсааны Абахуй ноён, Дархан ноён гэсэн хоёр ноёны хатан болсон ажээ.⁶ Хэрэв Ханджамц Дөрвөд гаралтай байсан бол гурвын гурван охиноо Түшээт ханыханд хадамд гаргасны хувьд түүнийг нь гэрчлэх ямар нэгэн ул мөр дөрвөдүүдийн дунд байх ёстой агал эдүгээ болтол тийм зүйл олдохгүй байгаа нь хачирхалтай.

Дээр нэр дурдагдаж буй Абахуй ноён гэдэг нь Абтай Сайн ханы дүү Абуху Мэргэн ноёны угсааны хэн нэгнийг хэлж байж магадгүй. Харин Дархан ноён нь Түшээт хан Гомбодоржийн дүү Лабдар Дархан ноёны угсааны хүн байж мэдэх юм.

Шашны түүхийн сурвалжуудад ийнхүү тэмдэглэсэн бол иргэний түүхийн сурвалжуудад Ханджамц хатны удам гарлын тухай мэдээ огт үзэгдэхгүй байна.

Хэрэв Ханджамц үнэхээр Дөрвөдийн Далай тайшийн охин байсан бол энэ талаар тухайн үеийн түүхийн баримт, сурвалжид цухас ч атугай дурдагдах учиртай. Мөн Дөрвөдийн ноёд Зүүнгарын ноёдтой адил Цорос овогтой тул Чахундорж, Галдан нарын маргааны үеэр ч энэхүү худ ургийн холбооны талаар дурдагдах ёстой агал тийм мэдээ огт алга байгаа нь Ханджамцыг Далай тайшийн охин гэж үзэхэд эргэлзээ төрүүлж байна.

Харин иргэний түүхийн сурвалжид Түшээт ханыхан Ойрадын хаад ноёдтой ураг барилдаж байсан тухай зурвас мэдээ тэмдэглэгдэн үлджээ. Тухайлбал, Манжийн төрөөс зохиолгосон “Зарлигаар тогтоосон гадаад монгол, хотон аймгийн ван гүнгүүдийн илтгэл шастир” (Бас “Илтгэл шастир” гэж дөхөмчлөн нэрлэдэг)-т дараах мэдээ гарч байна.

*Гучин зургадугаар он [Түшээт хан Чахундорж – Ц.Ц.] бараалхаар ирж, Торгуудын тайж Гүнгэ, Охин, Цэвдэн, Сандав таныг түүний эмгэний (эмгийн-Ц.Ц.) дүү Аюуки ханы төрлийн хүмүүн хэмээн төлөө алба бариулан оруулахуйг гуйж айлтгасанд зарлигаар явуулбай.*⁷

Очиртын гэргий Доржравдан жич Халхын Мэргэн хан Эриехэйн гэргий эд цөм Торгууд хан Аюукийн эгч мөн. Эриехэйн ач Чахундорж, цол Түшээт хан

⁶ Зава Дамдин, Сүмбүм, Нэгдүгээр боть, Авралт их дээдийн өрлөг эх, ах дүү хоёрын жасын гарал үүслийн тэмдэглэл оршвой, 1-4-р тал. (Д.Энхцэцэг, Ханджамц хатаны тухай – Oirad Studies 2, Budapest, 2016, 69-р талаас дам эшлэв)

⁷ Зарлигаар тогтоосон гадаад монгол, хотон аймгийн ван гүнгүүдийн илтгэл шастир (45-78-р дэвтэр), Монгол бичгээс кирилл бичигт буулгаж, тайлбар хийсэн Ц.Цэрэндорж, Л.Эрдэнэболд, Д.Баржав, Н.Ганбат, манж хятад эхтэй харгуулсан Ц.Цэрэндорж, УБ., 2009, Түшээт хан Чахундоржийн олдворын шастир, 11-р тал.

Үүнтэй ижил мэдээ “Магад хууль”-д гарч байгааг нанхиад эхээр нь сийрүүлбэл дараах байдалтай аж.

理藩院題、喀爾喀土謝圖汗請以其祖母族人厄魯特托爾果特阿玉什等之子孫四十餘台吉、請安進貢應不准行得旨、台吉衛寨桑龔格俄波、俄欽車卜登三都卜俱如土謝圖汗奏請准其請安進貢餘如議 (聖祖仁皇帝實錄 卷之一百八十四 康熙三十六年 七月日)。

хэмээгүй. Галданы Очиртыг дараар одсоныг /6 а/ сонсоод цэрэг авч өмөглөөр одож гүйцэгдсэнгүй. Доржравдан Торгуудад эрээр одвой.⁸

Үүний урьд Шүхэр дайчин Баатар хун тайжийн охиныг түүний хөвгүүн Пунсагт гэргий болгож аваад, Аюукийг төрж Баатар /8а/ хунтайжийн газарт тэжээх бөлгөө. Хо өрлөг нутаг нүүх цагт олж аваачсангүй. Хурд Торгууд Зүүнгар дугаа сэв болсон боловч басхүү таслаагүй. Хойно Шүхэр дайчин Тангудад одоод гэдэрэг буцахуйд Зүүнгарын газрыг дайрсны тулд Аюукийг авч эгвэй. Аюукид /8б/ нэгэн эгч, нэгэн охин дүү буй амуй. Эгчийг Халхын Мэргэн хан Эриехэйд гэргий болгож өгвэй. Охин дүүг Хошуудын Сэцэн хан Очиртод гэргий болгож өгвэй. Очирт бас түүний охиныг Аюукийн ахмад хөвгүүн Шагдаржавт гэргий болгож өгвэй. Эриехэйн ач Чахундорж бас ч /9а/ түүний охиныг Очиртын ач Лувсангүмбү аравданд гэргий болгож өгвэй. Чахундорж хэмээгч даруй Халхын Түшээт хан мөн. Галдан хэмээгч Аюукийн нагац мөн. Угтаа Очиртын ач охин Ануг гэргий болгож аввай. Хойно Очиртод муудаж аргадан алж, бас цэрэг авч Халхыг /9б/ дараар дарахуйд Чахундорж эсэргүүцэж чадахгүйн тул аймгийн ардыг авч дотор дагаар ирвэй. Вэй зайсан, Гүнгэ, Охин, Цэвдэн, Сандав хэмээгч Чахундоржийн эмгийн төрхөм мөн. Дагаар ирээд Халхын олон тайжийн хууль ёсоор алба барьж бараалхахуйг гуйсанд /10а/ зарлигаар явуулбай. Очирт алагдсаны хойно түүний гэргий Торгуудад эрээр одоод, түүний ах Аюукид түшиж суужухуй. Ануд нэгэн охин дүү буй амуй. Нэр Ахай. Галданы ахын хөвгүүн Цэвээнравдан гэргий болгож авсугай хэмээхуйд Галдан булааж аввай. Цэвээнравдан хорсч Борталд нүүгээд Аюукид /10б/ ураг бололцсугай хэмээн гуйсны тулд Аюук түүний охиныг гэргий болгож өгвэй.⁹

Дээрх сурвалжийн мэдээнд Халхын Мэргэн хан Эриехэйн гэргий, Хошуудын Очирт ханы гэргий нарыг Аюукийн эгч, эсвэл нэг нь эгч, нөгөө нь охин дүү гэх мэтээр зөрөөтэй тэмдэглэсэн байна. Ямартай ч, Чахундоржийн эмэг эх нь Торгуудын Аюуки хантай ах дүүгийн холбоотой байсныг дээрх мэдээнүүд харуулж байна.

Эдгээр мэдээнд үндэслэн Торгуудын ноёд, Цоросын ноёд хийгээд Халхын Түшээт ханы ургийн холбоог гаргавал дараах байдалтай байна.

⁸ Зарлигаар тогтоосон гадаад монгол, хотон аймгийн ван, гүнгүүдийн илтгэл шастирын далан есдүгээр дэвтэр, Шастирын жаран гуравдугаар, Алашаны Өөлд аймгийн шастирын хураангуй, 5-6-р хуудас.

⁹ Зарлигаар тогтоосон гадаад монгол, хотон аймгийн ван гүнгүүдийн илтгэл шастирын нэг зуун нэгдүгээр дэвтэр, Шастирын наян тавдугаар, Торгууд аймгийн шастирын хураангуй.



Одоо дээрх бүдүүвчид гарч буй хүмүүсийг нягтлан авч үзье. Судлаачид Оросын архивын баримтад тулгуурлан Хо өрлөгийг 1644 онд нас барсан гэж үздэг. Ойролцоогоор 75 насалсан гэж үзвэл тэрээр хамгийн эртдээ 1570 онд төрсөн бололтой. Хэрэв тийм бол, түүний хөвгүүн Шүхэр дайчин эртдээ л 1580-аад оны сүүлчээр, харин ач Пунсаг их л эртдээ 1605 онд, Пунсагийн охин хамгийн эртдээ л 1620-оод оны эхээр төрсөн байх учиртай. Гэтэл 1620 он гэхэд Эриехэй Мэргэн хан хэдүйн нас барж түүний хөвгүүн Гомбодорж хан ор залгасан байв. Үүнээс үзэхэд Аюукийн төрсөн эгч яаж ч бодсон Эриехэйн гэргий байх боломжгүй байна. Тэр тусмаа, Эриехэйгээс хамаагүй хожим амьдарч байсан Хошуудын Очирт сэцэн ханы гэргийтэй эгч дүү байх боломж маш хомс. Тиймээс Эриехэйн хатан нь Аюукийн төрсөн эгч бус, төрлийн эгч байж магадгүй.

Монгол сурвалжаас үзэхэд Эриехэйд Бинтү хатан (түүнээс Түшээт хан Гомбодорж төрсөн), Сүн тайху (түүнээс Ламжав Дайчин ноён төрсөн), Дэлгэр бэйж гэдэг хатад байжээ.¹⁴ Эдний дотроос Бинт хатан нь торгууд хатан байсан бололтой.

Үнэхээр Түшээт ханы хошуунд Торгууд баг хожим болтол байжээ. Угийн бичгээс нь үзвэл тэд Аюуки ханы дэд хөвгүүн Убаши сэцэний үр хойчис агаад 1915 оны байдлаар Торгууд багийн тайж нарын тоо 20 байжээ.¹⁵

Нөгөө талаар, Өндөр гэгээний зарим намтарт тэмдэглэсэнчлэн Ханджамц “Богдын түүний өвөг Очир их хааны дүүгийн охины охин мөн” гэсэн нь Очир их хаан гэдэг нь Өндөр гэгээний элэнц өвөг Абтай Сайн ханыг хэлж байна. Абтайд Абуху Мэргэн ноён, Хятад Илдэн хошууч, Түмэнхэн Хүндлэн цөхүр, Бахарай Хошууч ноён, Бодисун отгон ноён хэмээх дүү нар байжээ. Өөрөөр хэлбэл, эдгээр дүү нарын аль нэгийн нь зээ охин Ханджамц гэсэн үг болно.

¹⁰ Хо өрлөг - Торгуудын тэргүүлэгч ноён.

¹¹ Баатар хунтайж - Цорос буюу Зүүнгарын тэргүүлэгч.

¹² Очирт хан - Хошуудын тэргүүлэгч бөгөөд Ойрадын чуулганы дарга.

¹³ Ану - Галдан бошогтын хатан.

¹⁴ Шара-гуджи. Монгольская летопись XVII века, М., 1957, с. 167.

¹⁵ Н.Хатанбаатар, Халхын Түшээт ханы хошууны зарим отог, багийн үүслийн тухай - *Түүхийн судлал*, боть 40, УБ., 2010, 202-р тал.

Гэтэл Ханджамцын эцгийн нь тухай дурдаагүйгээс үзэхэд Ханджамцын эцгийн тал тийм ч өндөр гарал угсаатай байгаагүйг харуулж байна гэлтэй.

Тухайн үеийн Халх-Ойрадын ургийн холбооны тухай мэдээ харьцангуй хомс юм. Гэсэн хэдий ч энэ нь огт худ ураг барилддаггүй байсан гэсэн үг бус агаад Халх-Ойрадын худ ургийн харилцааг харуулах дам мэдээ ганц нэг тохиолддог. Тухайлбал: “Илтгэл шастир”-ын “Өөлдийн төрийн жүн ван Аравтаны олдворын шастир”-т *“Бас Халхын чин ван Цэвээнжав, жүн ван Гүмбү, Гүрүсихи-г бүрнээ Аравтаны ураг элгэн хэмээн зарлигаар тэднийг харьяат хүмүүн зарж, Аравтаныг олдон дагуултугай хэмээн тушаавай.”*¹⁶ гэдэг мэдээ гардаг. Засагт хан Шарын дүү Цэвээнжавын хувьд, түүний эгч Жал нь Галдан бошогтын үеэл ач Аравтаны гэргий байжээ. Харин Хүндлэн бошогт Гүмбү (Түмэнхэн Сайн ноёны 13-р хөвгүүн. Бас Гомбо гэх нь буй.), Гүрүсихи (Абатай Сайн ханы дүү Абуху Мэргэн ноёны жич хөвгүүн) нар Аравтантай ямар худ ургийн холбоотой байсан нь тодорхой бус байна.

Гэтэл дээр дурдсан Ханджамц хатны эгч буюу охин дүү нь Абахуй ноёнттой (Абуху ноёны үр хойчис бололтой) гэрлэсэн гэсэн мэдээ энд гарч буй Абуху ноёны угсааны Гүрүсихи-г Зүүнгарын Аравтаны “ураг элгэн” гэсэнтэй таарч байгаа нь сонирхолтой агаад хэрэв Ханджамц Ойрадын хэн нэгэн язгууртны охин байсан гэж үзвэл, үүгээр Абуху ноён, Зүүнгарын Аравтан нарын хооронд худ ургийн холбоог тайлж болох мэт. Гэвч цаашид шинэ мэдээ баримтыг хайн олж, энэхүү асуудлыг нягтлан судлах шаардлагатай, одоогоор баттай хэлэх боломжгүй байна. Ямартай ч, “Илтгэл шастир”-ын дээрх мэдээ нь Халх, Ойрадын ноёд язгууртны хооронд худ ургийн холбоо байсныг илтгэн харуулж байна гэлтэй.

Дээрх бүгдээс дараах зүйлийг тоймлон мэдэж болохоор байна.

- Өндөр гэгээний эх Ханджамц нь Дөрвөдийн Далай тайшийн охин мөнийг батлах найдвартай баримт үгүй байна. Одоогийн байдлаар Ханджамц хатны удам гарлыг нэгэн тийш шийдэх боломж үгүй, сурвалж бичгийн мэдээ харилцан зөрөөтэй байгаа тул түүнийг Дөрвөдийн Далай тайшийн охин гэж үзэх нь осолтой. Ялангуяа, “Өөлдийн” гэснийг “Дөрвөдийн”; “Далай хан” гэдгийг “Далай тайш” хэмээн “гүжирдэн” тайлбарлах нь зохимжтой бус хэмээн үзэж байна.
- Бидний гарт буй эх хэрэглэгдэхүүнд тулгуурлан Ханджамц хатны удам гарлыг нарийн тогтоох боломж хомс байгаа хэдий ч, Ханджамц нь Абтай Сайн ханы хэн нэгэн дүүгийн зээ охин байж магадгүй. Гэвч энэ нь тэрээр эцгийн талаараа Ойрадын аль нэгэн аймгийн язгууртны гэр бүлээс гаралтай байхыг үгүйсгэнэ гэсэн үг биш.

Тэгвэл юуны учир Ханджамцыг Дөрвөдийн Далай ханы охин гэж тэмдэглэсэн бэ гэдэг асуулт гарч ирнэ. Хэдийгээр баттай хариулт биш боловч, бид дараах таамаглалыг дэвшүүлж байна. Өндөр гэгээний эмэг эх нь Торгуудын

¹⁶ Зарлигаар тогтоосон гадаад монгол, хотон аймгийн ван гүнгүүдийн илтгэл шастир (45-78-р дэвтэр), Монгол бичгээс кирилл бичигт буулгаж, тайлбар хийсэн Ц.Цэрэндорж, Л.Эрдэнэболд, Д.Баржав, Н.Ганбат, манж хятад эхтэй харгуулсан Ц.Цэрэндорж, УБ., 2009, 161-р тал.

нөлөө бүхий язгууртны охин (Аюуки ханы төрлийн эгч байж магадгүй) байсан нь бидний дээр дурдсан баримтаар батлагдсан агаад ийнхүү Өндөр гэгээний дээд удамд Ойрадын нөлөө бүхий язгууртны охин байсан нь хожмын түүхчид Өндөр гэгээний эхийг ойрад гаралтай гэж үзэхэд хүргэсэн байж болохоор байна. Ийм үзэл Өндөр гэгээний амьдарч байсан цаг үеэс нэлээд хожим үүссэн болох нь ижил төстэй сурвалж дотор ч түүний эхийн гарлыг өөр өөр бичсэнээс харагдаж байна гэлтэй. Тиймийн учир хожмын түүх намтар бичигсэд Өндөр гэгээний эмэг эх ойрад хүн байсныг эх нь гэж ойлгоод, Торгууд аймгийг дээрх намтар бичигдэх үед Ойрадын гол аймаг болоод байсан Дөрвөд аймгийн Далай хан хэмээн ойлгосон байж мэдэхээр байна. Ер нь “Өндөр гэгээний намтар” нь маш олон хуулбар, хувилбартай, олон үе дамжин нэмж зохиогдсон шинжтэй сурвалж гэдгийг сануулахад илүүдэхгүй. Өндөр гэгээний эхийг Далай ханы охин гэж “сурталчлах” нь Манжийн эрхшээлийн үед Халхтай хамгийн ойр бөгөөд Ойрадын гол аймгийн үүрэг гүйцэтгэх болсон дөрвөдүүдийн дунд Богд Жибзундамба хутагтыг тахин шүтүүлэх, бурханы шашныг дэлгэрүүлэх, Богдыг нийт Ар Монголын бурханы шашны тэргүүн гэж хүлээн зөвшөөрүүлэх зэрэг суртал ухуулгын зорилготой байхыг ч үгүйсгэх аргагүй юм.

Нөгөө талаар, XVII зууны эхэн хагаст Дөрвөн Ойрадын дотор Хошууд, Торгууд, Зүүнгар аймаг ихээхэн хүчирхэг байж, Дөрвөд аймаг тэдэн лүгээ ижил хэмжээнд хүрээгүй байсан гэж таамаглаж болно. Абтай хан тэргүүтэй Халхын зүүн гарын ноёд Ойрадын хамгийн нөлөө бүхий аймгийн хан ноёдтой худ ургийн харилцаа тогтоохыг оролдсон нь мэдээж бөгөөд хожим Түшээт хан Чахундорж, Ойрадын чуулганы дарга Хошуудын Очирт хантай худ ургийн харилцаа тогтоож байсан нь үүнийг гэрчилнэ. Өөрөөр хэлбэл, Абтайн угсааны ноёд, ялангуяа түүний гол угсаа Ойрадын олон аймаг дотроос харьцангуй хүч буурай Дөрвөд аймгийн тэргүүнтэй худ ургийн холбоо тогтоосон байх магадлал бага гэж үзэж байна.

Гэвч бидний энэ таамаглал Ханджамц Дөрвөд аймгийн хүн байсныг бүрэн үгүйсгэж буй хэрэг бус, таамаглалын шинжтэй зүйл болохыг дурдсугай. Хожим шинэ мэдээ баримт олдож, Өндөр гэгээний эхийн удам гарал улам тодрох буй за.

Ашигласан ном зохиол

Сурвалж хэрэглэгдэхүүн

1. Агваанлуvsсандондов цорж, Өндөр гэгээний намтар, орчуулсан Ж.Ерөөлт, УБ., 2014.
2. Зарлигаар тогтоосон гадаад монгол, хотон аймгийн ван гүнгүүдийн илтгэл шастир (45-78-р дэвтэр), Монгол бичгээс кирилл бичигт буулгаж, тайлбар хийсэн Ц.Цэрэндорж, Л.Эрдэнэболд, Д.Баржав, Н.Ганбат, манж хятад эхтэй харгуулсан Ц.Цэрэндорж, УБ., 2009.
3. Зарлигаар тогтоосон гадаад монгол, хотон аймгийн ван, гүнгүүдийн илтгэл шастирын далан есдүгээр дэвтэр, Шастирын жаран гуравдугаар, Алашаны Өөлд аймгийн шастирын хураангуй.

4. Зарлигаар тогтоосон гадаад монгол, хотон аймгийн ван гүнгүүдийн илтгэл шастирын нэг зуун нэгдүгээр дэвтэр, Шастирын наян тавдугаар, Торгууд аймгийн шастирын хураангуй.
5. Өндөр гэгээний намтрууд оршивой, эрхлэн хэвлүүлсэн Ш.Бира, Ш.Сонинбаяр, Д.Дашбадрах, УБ., 1995.
6. Шара-туджи. Монгольская летопись XVII века, М., 1957.
7. Эрдэнэзуугийн түүх, Өндөр гэгээний намтар // Монголын түүхэн сурвалж бичгүүд- XIX боть, УБ., 2015.

Судалгааны зохиол

1. Д.Дашбадрах, Монгол-Түвэдийн улс төр, шашны харилцааны түүх (XVI-XVIII зуун), бот I, УБ., 2012, 53-р тал.
2. А.Очир, Занабазарын угсаа гарлын тухай- Өндөр гэгээн Занабазар: амьдрал, өв, УБ., 2015
3. Н.Хатанбаатар, Халхын Түшээт ханы хошууны зарим отог, багийн үүслийн тухай - *Түүхийн судлал*, боть 40, УБ., 2010, 196-203-р тал.
4. Д.Энхцэцэг, Ханджамц хатны тухай – *Oirad Studies* 2, Budapest, 2016, 60-74-р тал.